



УЛААНБААТАР
ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

ТОГТООЛ

1986 оны 9 сарын 04 өдөр

Дугаар 205

Улаанбаатар хот



Хотын архитектур төлөвлөлтийн газарт мөрдөх шагналын дүрэм шинэчлэн батлах тухай

Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТОХ нь:

1. Хотын архитектур төлөвлөлтийн газрын орон тоо зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан БИМАУ-ын Хөдөлмөр, цалин хөлсний улсын хороо, МҮЭ-ийн 1978 оны 38/38 дугаар тогтоолыг үндэслэн боловсруулсан тус газарт мөрдөх шагналын дүрмийг хавсралтын дагуу шинэчлэн баталж, 1986 оны 7 дугаар сарын I-ний өдрөөс эхлэн мөрдөхийг Архитектур төлөвлөлтийн газарт зөвшөөрсөгтэй.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны 1984 оны 197 тоот тогтоолыг хүчингүй болгосугай.



УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ДАРГА  С. МӨНХЖАРГАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ НАРХИН НИЛГЭЙН
ДАРГА  Ч. ЖАМБАЛ



ХОТЫН АРХИТЕКТУР ТӨЛӨӨЛӨЛГИЙН ГАЗАР
МӨРДӨХ ШАГНАЛЫН ДҮРЭМ

НЭГ. Үйлдвэрлэлийн инженер техникийн
ажилчин, ажилтны шагнал

Шинээр баригдах, өргөтгөх болон засварлагдах барилга байгууламж, тохижилт, гэрлэн чимэглэлийн зураг төсвийг хугацаанд нь чанартай боловсруулах, Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт баригдах барилга байгууламжийн байршилтыг оновчтой шийдвэрлэх, барилгын тэг тэнхлэгийг зургийн дагуу зөв байрлуулахад инженер техникийн ажилтан, ажилчдын материаллаг сонирхолыг өрнүүлэх зорилгоор шагналыг олгоно.

А. Зураг төсвийг чанартай боловсруулахад
олгох шагнал

1. Тухайн улиралд гүйцэтгэсэн нийт зураг төсвийн ажил нь хугацаандаа чанарын түвшинд боловсруулагдаж, ажлын чанарын үнэлгээ нь "Согоггүй зураг төсөв боловсруулах систем"-ийн дагуу 0,76-аас доошгүй байгаа нөхцөлд зураг төсөв зохиогчдод улирал бүр албан тушаалын сарын цалингийн 10 хувь хүртэл хувиар бодож шагнал олгоно.

2. Зураг төсвөөр дамжуулан шинэ бүтэц, хэрэглэж барилга угсралтын ажлыг хялбарчлах, орон нутгийн хямд материал тусгах зэргээр барилгын төсөвт өртгийг хямдруулсан байвал зураг төсөв зохиогчдод улиралд албан тушаалын сарын цалингийн 15% хүртэл хувиар бодон шагнал олгоно.

3. Улаанбаатар түүний дагуул хотуудын дэвсгэрт баригдах бүх төрлийн барилга байгууламжуудад газар олгох асуудлыг үндэслэл сайтай, чанартай боловсруулж шийдвэрлэх, гадаад дотоодны зураг төслийн байгууллагуудад боловсруулагдсан төсөл, техник эдийн засгийн үндэслэлийг хянаж зөвшөөрөлцөх, бүх төрлийн инженерийн хангамжийн техникийн нөхцлийг хянах, барилгын тэг тэнхлэгийг зургийн дагуу зөв байгуулах, газрын зургийг зохих нарийвчлалын дагуу чанартай хийж, **дежурин** зургийг цаг тухайд нь хөтөлсөн нөхцөлд хот төлөвлөлт байгуулалтын хэлтэс, геодези дежурин ерөнхий төлөвлөгөөний албаны ИТА-уудад улиралд албан тушаалын сарын цалингийн 10% хүртэл хувиар бодож шагнал олгоно.

Б. Зураг төсөв боловсруулах хугацааг
хорогдуулсанд олгох шагнал

4. Хотын төлөвлөгөөний комиссоор батлагдсан нэр төрлийн төлөвлөгөө, графикаар өгөгдсөн ажлуудыг чанартай зохион, нормативт хугацааг /хугацааны нормыг үндэслэн тогтоосон/ хорогдуулан гүйцэтгэсэн ажилтан, ажилчдад хугацаа хорогдуулсан хугацаанд ногдох албан тушаалын цалингаас нормативт хугацаанд эзлэх хувиар бодож олгоно.

5. Хариуцсан групп, товчооны хэмжээгээр улиралд хийгдвэл зохих зураг төсөв 100% хугацаандаа буюу хугацааны өмнө чанарын шаардлага хангаж иж бүрэн боловсруулагдсан байвал групп, товчооны /ЗТТ, БЗГ, ИСТ, ТТ, РЧГ/ дарга нарт улиралд сарын цалингийн 20 хувь хүртэл хувиар бодож олгоно.

6. Чанарын шагнал олгогдсон объектын зураг төслийг хэрэгжүүлэх явцад техникийн алдаа илэрвэл зөрчил илэрсэн улиралд тухайн зураг төслийг зохиогчид чанарын шагнал олгохгүй.

ХОЁР. Газрын улирлах инженер техникийн
ажилтан, ажилчид, туслах үйлдвэрийн
ажилтан ажилчдын шагнал

7. Хотын архитектур төлөвлөлтийн газрын дарга, ерөнхий инженер, ахлах ня-бо нарт борлуулалт, ашиг, нэр төрлийн төлөвлөгөөг биелүүлсэн нөхцөлд эхний хагас жил жилийн үйлдвэрлэлийн төлөвлөгөөний /үнийн дүнгээр/ биелэлтээр дор дурьдсан хэмжээгээр шагнал олгоно:

	: Үйлдвэрлэлийн төлөв- лөгөөний биелэлт хувиар	: Сарын цалингаас олгох шагналын хэмжээ
Архитектур төлөвлөлтийн газар	100-110 хүртэл 110-аас дээш	40 хүртэл хувь 50 хүртэл хувь

8. Хариуцсан групп, товчооны нэр төрлийн төлөвлөгөөг баталсан графикаар дагуу биелүүлж, зураг төсвийг чанартай сайн гаргаж, барилга байгууламжуудад газар олгох асуудлыг үндэслэл сайтай оновчтой боловсруулан шийдвэрлэх, барилгын тэг тэнхлэгийг зургийн дагуу зөв байгуулан ажилласан нөхцөлд товчоо, хэлтэс,

3.

амба, группын дарга нарт /ЭТТ, ХБТХ, ГДЕТА, ВЭГ, ИСТ, ТГ, РЧГ/ хагас бүтэн жилийн үйлдвэрлэлийн төлөвлөгөөний биелэлтээр /үнийн дүнгээр/ дараах шагнал олгоно:

Үйлдвэрлэлийн төлөвлөгөөний биелэлт /хувиар/	:	Сарын цалингийн олгох шагналын хэмжээ
100-110 хүртэл %	:	30 хүртэл %
110-аас дээш %	:	40 хүртэл %

9.Нэр төрөл аж ахуйн гэрээгээр аялууд хугацаандаа хийгдсэн, зураг төсөв боловсруулах техникийн баримт бичгийн бүрдүүлэлт сайжирсан нөхцөлд гэрээ захиалга хариуцсан мэргэжилтэнд хагас бүтэн жилээр сарын цалингийн 15 хүртэл хувиар бодож олгоно.

10.Байгууллагын эдийн засгийн гол үзүүлэлтийн /үйлдвэрлэл, ашиг, зардал, ХБ/ төлөвлөгөө биелсэн нөхцөлд эдийн засагчид албан тушаалын сарын цалингийн 15% хүртэл хувиар бодож шагнал олгоно.

11.Хагас бүтэн жилийн борлуулалтын төлөвлөгөөг биелүүлсэн зураг төсөв олгогчид албан тушаалын сарын цалингийн 15 хүртэл хувиар бодож шагнал олгоно.

12.Удирлын төлөвлөгөө биелүүлсний шагналд хамаарагдаагүй захиргаа аж ахуй, БАХА-ны ажилтнууд, хуулагч, төсвийн бичээч нар геодезийн туслах ажилчдад үйлдвэрчний хороотой зөвшөөрөлцсөний үндсэн дээр хагас бүтэн жилээр тэдний албан тушаалын сарын цалингийн 10 хүртэл хувиар шагнал олгоно.

ГУРАБ.Шагналын эх үүсвэр, шагнал олгох журам

13.Үйлдвэрлэлийн ИТА, ажилчдын шагналын фондыг тэдний жилийн цалингийн 8%-тай тэнцэх хэмжээгээр бодож газрын жилийн цалингийн фондоод оруулж батлуулна.

14.Удирдах ИТА, туслах үйлдвэрийн ажилтан, ажилчдын /дүрмийн "Б" зүйлийн 5,7,12-т заасны дагуу шагнагдагсад/ шагналын хөрөнгийг байгууллагын үйлдвэрийн фондоос гаргана.

15. Үйлдвэрлэлийн ИТА, ажилчдын шагналын дээд хэмжээ нь зураг төсөв зохиох хугацаанд ногдох албан тушаалын цалингийн 50%, удирдах ИТА нарт жилд олгох шагналын хэмжээ нь тэдний албан тушаалын нэг сарын цалингаас хэтэрч үл болно.

16. Зураг төсвийг чанартай боловсруулан, хугацааг хорогдуулсанд олгох шагналын хувь хэмжээг үйлдвэрчний эвлэлийн хороотой зөвшөөрөлцсөний үндсэн дээр газрын захиргааны хурлаар тогтоож батална.

17. Газрын дарга, ахлах ня-бо нарт олгох шагналыг хотны АИХ-ын гүйцэтгэх захиргааны захирамжаар, ерөнхий инженер, групп хэлтэс албадын дарга нарт, гэрээний мэргэжилтэн, эдийн засагч болон бусад ИТА, ажилчдын шагналыг газрын даргын тушаалаар батална.

18. Товчоо, хэлтэс, албадын дарга нарын саналыг үндэслэн үйлдвэрлэлийн ажиллагаанд зөрчил гаргасан, хөдөлмөрийн сахилга бат зөрчсөн ажилтан, ажилчдын шагналыг хасах буюу бууруулах эрхийг газрын дарга, ерөнхий инженер эдлэх бөгөөд шалтгааныг захиргааны хурлын протоколд тодорхой заасан байвал зохино.

19. Зураг төсвийг хүндэтгэх шалтгаангүйгээр хугацаа хэтрүүлэн, гүйцэтгэх, барилга байгууламжуудад газар олгох, тэг тэнхлэгийг байрлуулах ажлыг хугацаа алдаж гүйцэтгэсэн зэргээс үйлдвэрлэлийн төлөвлөгөөг тасалдуулсан ажилтан ажилчдын цалинг төлөвлөгөөний тасарсан хувьтай харьцаатайгаар бууруулан олгох, гэхдээ албан тушаалын сарын цалингийн 15 хувиас хэтэрч үл болно.